



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 01 сарын 13 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

┌ Хөрөнгө оруулалтын сангийн дүрэмд
өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай ┐

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.12, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.9, 55 дугаар зүйлийн 55.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. “ИББС хувийн ХОС” ХХК-ийн дүрэмд хавсралтад заасны дагуу өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолын 1-д заасан зөвшөөрлийг олгосонтой холбогдуулан компанийн дүрэмд өөрчлөлт оруулж, Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн энэ тухай Санхүүгийн зохицуулах хороонд ажлын таван өдрийн дотор мэдэгдэхийг “Юнити ассет менежмент ҮЦК” ХХК (Д.Бат-Очир)-д үүрэг болгосугай.

3. Тогтоол батлагдсантай холбогдуулан хөрөнгө оруулагч, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Юнити ассет менежмент ҮЦК” ХХК (Д.Бат-Очир)-д үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

1518000004